

## ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН МЭДЭЭ /2016 он/

Төрийн байгууллагын соёл болон төрийн албан хаагчдын ёс зүйг төлөвшүүлэх нь тус зөвлөлийн үндсэн чиг үүрэгт хамааралтай үүрэг, зорилтын нэг билээ.

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам”-ын 2.6, 2.7-д заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн Ёс зүйн хороо нь төрийн захиргааны байгууллагуудын ёс зүйн хороодоос төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн зөрчлийн мэдээг 2016 оны бүтэн жилийн байдлаар авч нэгтгэн ажиллалаа.

Төрийн захиргааны байгууллагуудын ёс зүйн хороонуудаас ирүүлсэн мэдээг нэгтгэн үзвэл 2016 онд нийт **193** ёс зүйн зөрчил бүртгэгдсэнээс:

- Төрийн захиргааны удирдах албан тушаалтантай холбоотой **19**,
- Төрийн захиргааны гүйцэтгэх албан хаагчтай холбоотой **174** ёс зүйн зөрчил бүртгэгдсэн байгаа нь өмнөх оныхтой харьцуулахад **5.4** хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Ёс зүйн зөрчлийг хүлээн авсан үндэслэл, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн зэрэг дэлгэрэнгүй байдлаар дараах хүснэгтээр нэгтгэн гаргав. Үүнд:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧЛИЙН ТУХАЙ 2016 ОНЫ МЭДЭЭ

2016 он	Ёс зүйн зөрчлийн тухай мэдээлэл хүлээн авсан үндэслэл					Зөрчлийг анх буюу давтан үйлдсэн аль нь болох		Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдал					
	Журмын 1.2		Журмын 2.2.5					Ёс зүйн хорооны дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн эсэх		Томилох эрх бүхий албан тушаалтны шийдвэр			
	Гомдлоор	Мэдээллээр	Хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээллийн мөрөөр	Ёс зүйн хороо өөрийн санаачлаар	Байгууллагын удирдлагын шийдвэрээр	Анх	Давтан	Зөвшөөрсөн	Зөвшөөрөөгүй	TATX-ын 26.1.1	TATX-ын 26.1.2	TATX-ын 26.1.3	Сахиулын шийтгэл ногдуулах шаардлагатай гэж үзсэн
Төрийн захиргааны удирдах албан хаагч	4	2		1	12	18	1	15	4	6	7	3	3
<b>Ёс зүйн зөрчил-19</b>													
Төрийн захиргааны гүйцэтгэх албан хаагч	92	3		2	77	148	26	143	31	58	54	10	52
<b>Ёс зүйн зөрчил-174</b>													
<b>НИЙТ ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛ</b>	<b>96</b>	<b>5</b>		<b>3</b>	<b>89</b>	<b>166</b>	<b>27</b>	<b>158</b>	<b>35</b>	<b>64</b>	<b>61</b>	<b>13</b>	<b>55</b>
<b>Нийт ёс зүйн зөрчил-193</b>													

Дээрх хүснэгтээс харахад төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчлийн талаарх иргэдийн гомдол, мэдээллийг үндэслэн ёс зүйн хороо авч хэлэлцсэн тохиолдол **96** байхад байгууллагын удирдлагын санаачлага, шийдвэрээр ёс зүйн зөрчлийг авч хэлэлцсэн тохиолдол **89** байна.

Харин ёс зүйн хороод хэвлэл мэдээллийн хэрэгслийн баримтат мэдээлэл болон өөрийн санаачлагаар төрийн албан хаагчийн ёс зүйн үйлдлийг авч хэлэлцсэн тохиолдол харьцангуй цөөн байна. Энэ нь ёс зүйн хороод өөрийн санаачлагатай, идэвхитэй ажиллах байдал сулавтар байгааг харуулж байна.

Ёс зүйн зөрчлийг анх удаа гаргасан **166** албан хаагч байгаа бол давтан гаргасан **27** албан хаагч байгаагаас Ёс зүйн хорооны дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн **158**, хүлээн зөвшөөрөөгүй **35** албан хаагч байна.

Ёс зүйн хороодын дээрх шийдвэрээр төрийн албан хаагчдад ногдуулсан сахилгын шийтгэлийг төрлөөр авч үзвэл:

- 64 албан хаагчид-сануулах /ТАТХ-ийн 26.1.1/,
- 61 албан хаагчид-албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах /ТАТХ-ийн 26.1.2/,
- 13 албан хаагчид-төрийн албанд 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах /ТАТХ-ийн 26.1.3/ гэсэн сахилгын шийтгэлийг тус тус ногдуулжээ.

Харин төрийн захиргааны албан хаагчийг ёс зүйн зөрчил гаргасан гэх мэдээллийг Ёс зүйн хороодоос хянан шалгаж, **55** албан хаагчдад сахилгын шийтгэл хүлээлгэх шаардлаггүй буюу ёс зүйн зөрчил гаргасан гэх өргөдөл, гомдол, мэдээлэл үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.

Эндээс харахад материаллаг /цалин бууруулах/ болон ёс зүйн /сануулах/ шийтгэл зонхилж байгаа нь харагдана. Төрийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэл нийт сахилгын шийтгэлийн 9.5 хувийг эзэлж байна.

Төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчлийн тухай сүүлийн 5 жилийн байдлыг харьцуулан үзэхэд өнгөрөгч 2016 онд бүртгэгдэж ёс зүйн хороодоор хэлэлцэгдсэн зөрчлийн тоо өмнөх жилийн буюу 2015 оны дүнгээс **19** буюу **8.9** хувиар буурсан байна.

Ёс зүйн зөрчлийг сүүлийн 6 жилийн байдлаар харьцуулан үзвэл:

